

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

1996 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 114

Улаанбаатар
хот

Үнэт цаасны арилжааны
мэдээний үзүүлэлтийг өөрчлөх тухай

Монгол улсад хөрөнгийн зах зээл төлөвшиж, хөрөнгө оруулагчид үнэт цаасны зах зээлийн ханшийн болон бусад мэдээллийг дэлгэрэнгүй өгөх бололцоо, мэдээллийг хөгжсөн орны жишигт хүргэх шаардлага зэргийг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос **ТОГТООХ** нь:

1. Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны мэдээний үзүүлэлтийг хавсралтад дурдсанаар зөвшөөрсүгэй.
2. 1997 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн зөвшөөрсөн үзүүлэлтээр үнэт цаасны арилжаа, индексийг өдөр бүр төвийн хэвлэлээр мэдээлж байхаар тогтоосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хорооны 1996 оны 02 дугаар сарын 01-ний 12 дугаар тогтоолын 2 дахь заалт, хавсралтыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

Монгол Улсын Үнэт цаасны хорооны 1996 оны
12 сарын 26-ны өдрийн
114 тогтоолын хавсралт

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны мэдээ

Сүүлчийн 52 долоо хоногийн ханш		Хувьцааны нэр	ангилал	Нэгж хувьцааны			Арилжаалагдсан ширхэг	1996.12.26-ний өдрийн ханш				Ханшийн өөрчлөлт
Дээд	Доод			Ногдол ашиг	Ногдол ашгийн өгөөж /%/	Цэвэр ашгийн өгөөж		Дээд	Доод	Хаалт	Дундаж ¹	
570	58	АПУ	А	85	16.67	364.33	...	560	505	510	-25	
1900	20	Монгол	В	54.96	762	1500	510	800	50	
100	50	Шаазан Эрэлмаш	С	

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

Тайлбар

1. Сүүлчийн 52 долоо хоногийн арилжааны хамгийн дээд доод ханш,
2. МХБ-ийн бүртгэлд орсон хувьцаат компанийн нэр,
3. МХБ-д бүртгэлтэй үнэт цаасыг “МХБ-д үнэт цаас бүртгэн авах тухай “ МХБ-д үнэт цаас бүртгэн авах тухай” журмын дагуу А, В, С гэсэн 3 ангилалд хуваасан байдал.
А- найдвартай, эрсдэл багатай дээд ангиллын үнэт цаас
В- Зохих шалгуур хангасан дунд ангиллын үнэт цаас,
С- Найдваргүй , эрсдэл өндөртэй доод ангиллын үнэт цаас
4. Тухайн компанийн сүүлчийн нэг жилд нэгж хувьцаанд олгосон ногдоол ашгийн хэмжээ
5. Ногдол ашгийн хэмжээг тухайн арилжааны өдрийн хаалтын ханшид харьцуулан тодорхойлсон нэгж хувьцааны ногдол ашгийн өгөөж
6. Компанийн тайлант жилийн татавар хассаны дараах цэвэр ордогыг компанийн нийт гаргасан хувьцааны тоонд хувааж гаргасан нэгж хувьцааны цэвэр ашгийн өгөөж.
7. тухайн өдөр арилжаалсан хувьцааны тоо, ширхэг,
8. Арилжааны тухайн өдрийн ханш
9. Ханшийн өөрчлөлт /төгрөгөөр/

¹ Үнэт цаасны хорооны 1997 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор нэмсэн.